

УГСААТНЫ ЗӨРЧИЛ ТЭМЦЭЛ ГАРАХ ШАЛТГААНЫ ТУХАЙД

И. Саруул МУИС НШУС Нийгэм соёлын антроплогийн тэнхим. дэд профессор

Түлхүүр үг : түгшүүрт байдал, нутаг дэвсгэрийн маргаан, түүхэн ой ухаан, сэтгэлгээ, дүрвэлт.

Угсаатны зөрчил тэмцлийн гухай асуудал нь нийгмийн философийн нэг асуудал мөн. Энэхүү асуудал нь орчин үед дэлхий нийтийн анхаарал татсан асуудлуудын нэг болж байна.

Өдгөө дэлхий бөмбөрцөг дээр тогтнож буй нийт 200- аад улс орны бүрэлдэхүүнд хэдэн мянган угсаатны нийтлэгүүд оршиж байна. Зөвхөн Энэтхэгт гэхэд л 100, Индонезид 150, Нигерид 200, Кенид 70 гаруй байна. Тэдгээрийн хүн амын тооны өсөлт, улс төр, нийгэм – эдийн засаг, угсаатны нийгмийн хөгжлийн түвшин зэрэг нь харилцан адилгүйн дээр хоорондоо эрс ялгардаг. Эл байдал нь нийгмийн харилцаанд нь шууд нөлөөлөх бөгөөд элдэв зөрчил мөргөлдөөнд тулгаж, тэмцэл өрнөх хугацаанд ч нөлөөлдөг. Жишээлбэл, Ольстер дэх ирланд – англичуд, Бельги дэх фламан – вавилончууд, Канад дахь англи, франко – канадчуудын тэмцэл хэдэн арван жилээр сунжирч байхад ОХУ – ын БНУ –ууд, Югослав, Африк зэрэгт зөрчил тэмцэл нь сүүлийн 10 – 15 жилийн хугацаанд эрс хурцдан өрнөж буй. Стокгольмын Олон Улс Судлалын хүрээлэнгээс гаргасан судалгаанаас харахад 1990 – ээд онд дэлхийд тулгарсан цэргийн бүх мөргөлдөөний 70% нь угсаатны зөрчил тэмцлийн сэдэлтэйгээр тэмдэглэгджээ. Иймд нийгмийн зөрчил тэмцлийн нэгэн бүрэлдэхүүн нь угсаатны зөрчил тэмцэл байдаг бөгөөд хамгийн хүнд хэцүүхэн, хурц тэмцэл болно. Зөрчилдөж буй талуудын ил ба далд / латентный / зөрчлийг иж бүрэн хүчин зүйлүүд бүрдүүлдэг учраас хамгийн зөрчилтэй ойлголтод хамаардаг.

Угсаатны зөрчил тэмцэл нь ямагт нийгэм-улс төрийн үзэгдэл байна. Зөвхөн соёл, хэл эсвэл нийгэм – эдийн засгийн тодорхой салбарт өөрчлөлт шинэчлэлт хийхийг эрмэлзэвч, зорилгодоо хүрэх гагц бололцоо нь засгийн эрх олсноор биелэх тавилантай. Тиймээс нийгмийн шинжлэх ухаануудын судалгааны нэгэн чухал чиглэл, түүнийг шийдвэрлэх арга замыг боловсруулах чухал сэдэв болно.

Угсаатны зөрчил / тэмцэл / гарах үндсэн шалтгаан. Угсаатны зөрчил нь тэдний оршин байгаа нийгмийн улс төр, нийгэм – эдийн засаг, түүхэн шалтгаанаар сэдэгддэг. Угсаатны зөрчлийг хүсэн хэрэгжүүлж буй зорилго, гарах шалтгаанаар нь үндсэн ба дагалдах шалтгаанд төрөлжүүлдэг. Үндсэн шалтгааны төрөлд: - Угсаатан хоорондын түгшүүрт байдал; - Нутаг дэвсгэрийн маргаан тэмцэл; - Дүрвэлт, шилжин суурьших; - түүхэн ой ухаан, сэтгэлгээ; - Ард түмнээс хувь заяагаа шийдвэрлэх эрмэлзлэл; - Байгалийн баялгаа хамгаалах эзэмших; - Үндэсний элитүүдийн статусаа сайжруулах хүсэл эрмэлзлэлийн шаардлагууд; - Хөдөлмөрийн зах зээлийн хувиарлалтын төлөө тэмцэл зэрэг хамаарна.

Угсаатны нийтлэг хоорондын түгшүүрт байдлын ойлголт. Угсаатны бүх төрлийн зөрчил нь угсаатан хоорондын түгшүүрт байдлаас үүдэж эхэлдэг бөгөөд угсаатны зөрчил тэмцлийн үндсэн шалтгаанд онцлогддог.

Угсаатан хоорондын түгшүүрт байдал гэж угсаатны нийтлэгийн сэтгэл, сэтгэл зүй, сэтгэл санааны онцгой байдал болно. Угсаатны нийтлэгийн ухамсрын түвшинд гадаад хүчин зүйл нөлөөлсөн тусгалаар нөхцөлдөн тогтдог. Угсаатны нийтлэг нь биологи – нийгэм – соёлын тогтолцоо байдгийн хувьд гаднаас харшилах ямар ч үйлдэлтэй нэг бол эсэргүүцэн тэмцэх, эсвэл түүнтэй дасан зохицох хувилбаруудыг хэзээд сурвалжилж байдаг. Иймээс угсаатны нийтлэгийн зөвхөн сэтгэл зүйн үзэгдэл төдийгөөр хязгаарлагдахгүй, мөн өөрсдийнхөө ашиг сонирхлоо хамгаалах сэтгэл зүйн бололцоо нөөцөө дайчлах арга барил юм.

Угсаатны түгшүүрт байдал хир хурцатсан нь угсаатны бүлгүүдийн хооронд тогтсон харилцаа холбоо, түүний түүхэн шинж чанар, соёлын онцлог харилцааны бүтэц, агуулга зэргээс шалтгаална. Эдгээр бүрдлүүд нь тэдний ухамсарт бүрэлдэн тогтсон төсөөлөл, санал бодол, итгэл үнэмшил зэрэг хэлбэрээр амь бөхтэй оршидог. Угсаатны харилцааны түүхэн үнэлэмжийн мэдлэгт хамаарах угсаатны соёлын удирдамж, зан араншингийн төлөв, мөн угсаатны түүхэн сэтгэлгээний хэлбэрээр байдаг.

Угсаатны түгшүүрт байдал бүрэлдэн тогтоход угсаатны бүлгүүдийн харилцааны түүх ихээхэн нөлөөлдөг. Түүхэн ой санамж нь угсаатан үндэсний гомдол, талархлыг их төлөв үе дамжин тогтоон санадаг. Хууч түүхийг өнөөгийн түүхэн үүднээс үнэлж ашигладаг байна. Түүхэн сэдэвт цуглаан нь нийгмийн түгшүүрт байдлыг угсаатны түгшүүрт байдалд шилжихэд дөхөм болдог. Ард түмнээ хүндхэн байдлаас гаргахын тулд буруутныг хайж олох, түүхэн дайснаа буруутган давшлахад тун хялбар байна.

Угсаатны түгшүүрт байдал нь нийгмийн сэтгэл зүйн орчин болохын бодьгалийн хувьд сэтгэл хөдлөл, итгэл үнэмшил, дууриал зэргээр халдварлан бусдыг дагуулан хамруулдаг тулгуурладаг. Тухайлбал, цуглаан дээр хувь хүний сэтгэл догдлол / үзэл бодол / нь олонд дамжих замаар хувь хүний хариуцлагаас түвэггүй мултарна. Сэтгэл судлаачдын ажигласнаар угсаатны нийтлэгт кумулятив сэтгэлгээ буюу харгис сэтгэл хөдлөлийн хурцдал үйлчилдэг. Иймд олны дунд сэтгэл хөдлөлийн гоомой ажиллагаанд шилжихэд хялбар нөхцөл бүрддэг. Түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд олон түмэнд удирдагч, удирдах хэсэг шаардагдана. Энэ тохиолдолд угсаатны түгшүүрт байдлыг хурцатган хүчирхийллийн шатанд дэвших магадлал тун өндөр байна.

Угсаатны түгшүүрт байдлыг хурцатгах нэгэн хүчин зүйл бол цуурхал юм. Цуурхал албан ёсны бус харилцаанд маш идэвхтэй үйлчилж байдаг. Цуурхал бол бодит, эсвэл зохиомол үйл явдлыг гажуудуулсан тайлбарлал байдаг. Тэхдээ угсаатны нийтлэгийн далд санаа бодол, хүсэл эрмэлзлэлийг ямагт илэрхийлж байдаг. Тиймээс бас анхаарахгүй байж болдоггүй, учир нь Олон улсын мэдээллийн системийн мэдээг хэтрүүлэн гуйвуулж шинэ цуурхал дэгдээхэд хүргэдэг.

Улс төрийн түгшүүрт байдалд нийгмийн бухимдал ихээхэн нөлөөлдөг. Тэр нь үндэсний соёлын уусалт явагдахаас эмээх явдал юм. Энэ байдал нь сэтгэл хөдлөлөөр санаа зовоох, цухалдах, сандрах, цөхрөх, сэтгэл догдлох зэрэгт хүргэдэг болзошгүй. Өөрөөр хэлбэл, таагүй сэтгэл хөдлөлийн өнгө аясыг бүрдүүлдэг. Энэ үндсэн дээр угсаатны эв нэгдлийг сахиулах шаардлага идэвхтэй өрнөдөг.

Угсаатны түгшүүрт байдал тун хялбархан бүрддэг, харин түүнээс гарахад тун бэрхшээлтэй, нөр их хөдөлмөр, хугацаа шаардагддаг байна. Энд төрийн идэвхтэй үйл ажиллагаа, нөсөр зардал шаардагдана.

Нутаг дэвсгэрийн маргаан. Орчин үед дэлхий дээр оршин байгаа 200 гаруй улсын нутаг дэвсгэрт угсаатны нийтлэгүүд оршин сууж буй. Эдгээр улс байгуулагдах түүх нь нутаг дэвсгэрийн төлөө зөрчил тэмцлийн явцад тогтсон билээ. Орчин үеийн ард түмнүүдийн тусгаар төр улс байгуулахын төлөө тэмцэлд ямагт бусад ард түмэн /угсаатан /, эсвэл бусад улсын нутаг дэвсгэрээс таслан авах үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Томоохон угсаатнууд нь хэдийнээ нутаг дэвсгэрээр зохион байгуулагдсан хүмүүсийн нийтлэг тул нутаг оронд нь халдах ямар ч оролдлогыг үл тэвчидэг. Тиймээс угсаатны түүхэн хөгжилд нутаг дэвсгэрийн маргааны асуудал нэгэн чухал чиглэл байдаг бөгөөд ямагт сахин хамгаалж байхыг шаарддаг.

Нутаг дэвсгэрийн маргаан тэмцлийн зорилго нь тогтож байгаа газар шорооны эзэмшлийг ашигтайгаар эрхийг нь өөрчлөн эзэмшихийг шаарддаг. Зорилгодоо хүрэхийг эрмэлзэхдээ хууч түүхийн сурвалж баримтанд тулгуурлан бэрхтэй шаардлагаа үндэслэдэг. Тодруулбал, өнгөрсөн түүхэнд аль нэг угсаатны эзэмшилд ямар нэгэн газар нутаг байсныг баталдаг бөгөөд энэ үндсэн дээр эргэн харъяалах эрхээ тунхагладаг. Тэхдээ маргалдагч талууд тус тус түүхэн үндэслэлээ дэвшүүлж, түүнийгээ маргашгүй үнэн гэж итгэлтэй байдаг. Байдлыг геополитикийн хувьд байгаагаар нь авч үзвэл түүхэнд нилээд хугацаа өнгөрөхөд хэдэн удаагийн миграци, эзлэгдэн захиргаа солигдож байсан зэргээс тус нутаг орны угсаатны тархан суурьшилт нь хэд дахин өөрчлөхийн хамт улсын хилийн шугам ч өөрчлөгдөж иржээ. Маргалдагч талууд түүх рүү гүнзгийрсэн үндэслэл хийх тусам маргааныг таслан шийдвэрлэх бус, харин ч хүндрүүлдэг байна. Түүнийг улс төрийн удирдагчдаас хөдөлгөөнийхөө хөтөлбөрт оруулж тунхаглах нь мөргөлдөөнд хүргэх үндсэн шинж бөгөөд цухалдсан хүмүүс олишрч харш үйлдэлд хүргэдэг. Тэгснээр ердийн үг хүртэл түрэмгий харгис мэт ойлгогдож бусдын дургүйцлийг хүргэж үл таашаагдах байдалд хөтөлдөг. Энэ үндсэн дээр харь ба өөрийн угсаатны ялгаа зааг улам ангалтай болдог. Тэгснээр өөрийн угсаатны бүлгийн үйлдлийг эерэг, харийн ард түмнийхийг сөргөөр үнэлэх явдал гардаг. Өөрөөр хэлбэл, бүх ололт амжилт бол өөрсдийн зүтгэл гавъяагаар алдаршуулж, алдаа мадаг бүхнийг харь дайсных буюу бусад угсаатанд нялзаан адалдаг. Иймээс нутаг дэвсгэрийн маргаан бол туйлын хүнд тэмцлийн хэлбэр байдаг.

Улс төрийн байдлын хурцдал, мэдээллийн хомсдол, түнш ард түмнүүд хамтран үл ойлголцох явдал нь түрэмгийлэгч, хядан довтлогчийн байдлыг төрүүлдэг. Сэтгэл зүйн ийм байдалд хувь хүн зөв үр ашиг хүртэж чадахгүй байдалд оруулдаг. Ийм нөхцөлд тэмцэлдэгч аль ч талын ямар ч үйлдэл нь нөгөө талын эрс эсэргүүцэлтэй тулгарч, эцэстээ мөргөлдөхөд хүргэдэг. Иймд угсаатны зөрчил тэмцэл гэдэг бол нэг талаас харъяалагдаж байгаа улсынхаа төр засаглал, нөгөөтэйгүүр тус улсын бүрэлдэхүүний бусад угсаатнуудтай ашиг сонирхол, зорилго авцалдахгүйн нөхцөлөөр бүрдсэн нийгмийн онцгой байдал юм.

Угсаатны нутаг дэвсгэрийн тэмцэлтэй холбоотой хоёрдох чиглэлийн асуудал бол тусгаар тогтносон улс байгуулагдахтай холбоотой юм. Өдгөө ихэнх угсаатнууд нь өөрийн тусгаар улсгүй билээ. Гэвч тэдгээрт ардчилал, эдийн засаг, соёл хөгжих тусам угсаатны статус дээшлэн

батжихын хамт тусгаар тогтносон үндэсний улс байгуулах хөдөлгөөн өрнөдөг байна. Даангүй урд өмнө түүхэнд тусгаар улсын хэлбэрээр оршин байгаад хожим түүнийгээ алдсан угсаатанд ийм хөдөлгөөн олныг хамарч эрчимтэй өрнөдөг байна. Тухайлбал, Грузин – Абхази, Армян – Азербайджаных хамаарна. Угтаа нутаг дэвсгэрийн төлөө тэмцэл нь төр улсынхаа статусыг өөрчлөх эрмэлзлэлтэй нягт холоотой явагддаг бөгөөд хурц тэмцэл бүхий угсаатны зөрчлийн тэмцлийн шалтгаан байдаг.

Байгалийн баялгаа хамгаалан эзэмшихийн төлөө тэмцэл. Экологийн байдал, байгалийн түүхий баялаг нь мөн угсаатны зөрчил тэмцлийг хурцатгах нэгэн хүчин зүйл байдаг. Иймэрхүү зөрчилд маргалдагч талууд байгалийн баялаг, түүхий эд бүхий газрыг эзэмшин ашиглах түүхэн эрхийн үндэслэлийг дэвшүүлж зөвтгөдөг. Өөрөөр хэлбэл, өдгөө тогтсон байдлыг өөрчлөх явдал юм. Энэ нь орон нутгийн удирдагчдыг федерал төвийн засаглалтай зөрчилдөн тэмцэлдэхэд хүргэдэх байдлаар угсаатны нийтлэгээс бүрэн эрхт байдал руу эрмэлзэх тэмцлийн хэлбэр юм.

Орон нутгийн удирдагчдын статусыг сайжруулах эрмэлзлэл. Статусын мөргөлдөөний зорилго нь орон нутгийн автономийн захиргаа, тэдний удирдагчдын улс төр, эдийн засгийн эрх мэдлийг ихэсгэн баталгаажуулахад чиглэгддэг. Иймэрхүү төрлийн угсаатны мөргөлдөөн нь их төлөв шилжилтийн үеийн нийгэмд үүсдэг бөгөөд нийгмийн зөрчил тэмцлийг угсаатны зөрчилд шилжүүлэн хүчийг нь сааруулах зорилготой өрнөдөг. Шилжилтийн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн эрх мэдэл, түүхийн эдийн өмчлөлийг шинэчлэн хуваарилан захирахад чиглэгддэг. Энэ хэв маягийн угсаатны зөрчлийн үндэс нь ард түмний оюуны хөгжлийн шинэчлэл байдаг. Угсаатны нийтлэгт оюунчлагдсан удирдагчдыг бий болгох нь нэр хүнд бүхий /престижных видах деятельности/ дээд албан тушаалд титуль ба гол угсаатнуудын хооронд өрсөлдөгч бий болгоход хүргэдэг. Титуль угсаатны төлөөлөгчид өөрсдийгөө бие даан үйл ажиллагаа явуулах чадварта гэж бодож, дээд ба баталгаат албан тушаалуудыг эзлэхийг оролддог бөгөөд засгийн өндөрлөгийн албан тушаалууд хамаарна.

Дарангуйллаас /тоталитаризм/ ардчилалд шилжих шилжилтийн үеийн тогтворгүй байдалд автономит угсаатны улс төрийн бүлгүүд угсаатны нийгмийн давхраажилтын нийгмийн тогтолцоог өөрчлөхөд дөхөм үзүүлж байдаг. Ингэхэд угсаатны шинээр төрсөн удирдагчид өөрсдийн явцуу эрх ашгаа угсаатны ашиг сонирхлын асуудлаар далдалдаг тул янз бүрийн саатал гарах явдал цөөнгүй. Тэгэхдээ угсаатанд шинэ нийгэм, эдийн засгийн тогтолцоонд орших байр сууриа тогтоон баталгаажуулдаг. Ийм төрөлд Чечений мөргөлдөөн хамаардаг.

Хөдөлмөрийн хуваарийн тогтолцооны өөрчлөлт. Түүхийн практикаас харахад олон угсаатны бүрэлдэхүүнтэй ихэнх улсуудад угсаатны бүлгүүдийн хооронд хөдөлмөрийн хуваарийн тогтолцоо зүй ёсоор /естественным/ тогтсон байдаг. Хөдөлмөрийн салбарууд янз бүрийн хөдөлмөр зарцуулалт шаардахын хирээр орлогын хэмжээ нь ялгаатай байдаг тул тэдний хооронд далд өрсөлдөөн үүсч, ямагт хичнээн хөдөлмөр зарцуулж, хичнээн орлого хураасныг харьцуулан хардаж байдаг. Хөдөлмөрийн салбарууд ба угсаатны нийтлэгүүдийн хамааралт байдал байгаа цагт энэхүү өрсөлдөөн нь угсаатны бүлгүүдийн хооронд шилжиж өрнөдөг байна. Үүний үр дүнд угсаатнуудын хооронд угсаатны түгшүүрт байдал буюу мөргөлдөөний эхний шинж бүрэлдэн тогтдог байна.

Түүхэн ой ухаан, сэтгэлгээ. Ард түмний түүх угсаатны мөргөлдөөний нэгэн онцгой шалтгаан болдог байна. Ямар ч ард түмний түүх нь үнэлэмжийн түүх байдаг, үеэс үед дамжуулагддаг, түүнд эерэг ба сөрөг түүх арвин байдаг. Түүхэн ухамсар нь бусад угсаатанд хандах хандлагыг тодорхойлж байдаг. Тухайлбал, ямар нэгэн ард түмнийг хүчээр эзэлсэн, угсаатныг дураар таслан тараасан, нутаг дэвсгэрийг нь булаасан, дотоод хязгаарыг нь зохиомлоор тогтоосон, улс төрийн харгис бодлого, дотоод хэрэгт нь хутгалдсан зэрэг нь мартагддаггүй байна. Угсаатантай холбоотой ямар ч зөрчил тэмцэлд түүх нь хамгийн их нөлөө үзүүлж хурцатгах, эсвэл эерэг үр дүн үзүүлдэг. Эерэг үр дүнд хүрэхийн тулд угсаатнууд түүхээ бодитоор нь авч үзэж, сургамж авч сайн талуудыг нь түлхүү гаргах ёстой, ингэснээр ямарваа аюулаас зайлах бололцоотой.

Энэ бүхнээс үзэхэд угсаатны зөрчил тэмцлийн түмэн шалтгаан байх бөгөөд улс орон, ард түмний хөгжлийн хамт ямагт баяжин нэмэгдсээр байдаг байна. Тиймээс шалтгаан бүрийн онцлогийг сайтар нягталж мэдэх шаардлагатай. Ингэхдээ шалтгаан нь ямагт шинэчлэгдэн хувирч байдаг тул мөргөлдөөн ч мөн шинэ хэлбэртэй болж хурцатдагийг анхаарах шаардлагатай.

Ашигласан ном зохиол

1. Арутюнян Ю.В., Дрбижева Л.М., Сусоколов А.А. Этносоциология—М., 1998
2. Кармин А.С. Основы культурологии. Мирфология культуры. — Санкт — Петербург, 1997.
3. Стефаненко Т. Этнопсихология. — М., 2000.
4. "Этнос и политика". — М., 2000.